



# **ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИ 2015-2020**

---

**Хүйсийн тэгш эрхийн төв**

Улаанбаатар хот 2015

**ХХГХ-тэй тэмцэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлэх ажлын үзэл баримтлал, Стратегийн баримт бичиг**

**Хүйсийн Тэгш Эрхийн Төв (ХТЭТ)  
Азийн Сангийн тусламжтайгаар боловсруулав**

**ЗОРИЛГО:** Хүйсийн тэгш эрхийн төвөөс Монгол улс дахь ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгаалах хөтөлбөрүүдээ өргөжүүлэн бэхжүүлэхийн тулд 2015 оны 6-р сараас 2020 оны 6-р сар хүртэл 5 жилийн хугацаанд үйл ажиллагааны стратегийн болон санхүүгийн тогтвортой бие даасан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.

**ЗОРИЛТ:**

1. ХХГХ-тэй тэмцэж буй өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох
2. 2015-2020 онд ХХГХ-тэй тэмцэхэд баримтлах нэн тэргүүний асуудлуудыг тодорхойлох
3. ХХГХ-тэй тэмцэх стратегийг хөтөлбөр тус бүрээр гаргах
4. Дотоод болон гадаадын хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийг тодорхойлох
5. Ажилтнуудыг мэргэшүүлэх, тогтвортой байдлыг хадгалах чиглэлээр

**ЗАРЧИМ:**

1. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
2. Хохирогч хамгаалал
3. Нөхөн сэргээх
4. Хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх

**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2002 оны 1 сарын 4-нд байгуулагдсан цагаасаа эхлэн Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод шууд туслалцаа үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Өнгөрсөн хугацаанд нийт 1500 гаруй хүнд туслалцаа үзүүлэн ажилласны 583 нь (2014.12.31) нь хүний наймааны хохирогчид байлаа. Хохирогчдын 87.4% нь охид эмэгтэйчүүд, 63.5% нь бэлгийн, 25,8% нь хөдөлмөр мөлжлөгийн хохирогчид бөгөөд тэдний 2 хүн тутмын 1 нь БНХАУ-д, 4 хүн тутмын 1 нь эх орон дотроо худалдагдсан үйлчлүүлэгчид юм. Тэдний 288 нь Улаанбаатар хотын, 135 нь Замын-Үүд дэх түр хамгаалах байранд дунджаар нэг хүн 30 хоног байрласан байна.

Нийт хохирогчдийн 54.5% нь хуулийн байгууллагад хандсан бөгөөд 5 хүн тутмын 1 шүүхээр асуудал нь шийдвэрлэгдсэн. Харамсалтай нь хохирогчид ихээхэн зориг, тэвчээр гарган хуулийн байгууллагад хандсан ч хэргүүд хэрэгсэхгүй болох, хохирогчийг буруутгах үзэл хандлага, гэрч, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалт байхгүй, хэргийг хянан шалгах хугацаа хэт их байдаг учир дийлэнх хохирогчид хуулийн байгууллагад хандах итгэлээ алдах асуудал байсаар байна. Тухайлбал: Малайз улсад хүн худалдаалах гэмт хэрийн хохирогч болсон иргэд 2008 онд хуулийн байгууллагад хандсан ба улмаар хэрэг 2012 онд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн ч гэмт хэрэгтнүүдэд 3.6 жилийн ял оногдуулсан. Харамсалтай нь хохирогчдод хохирол нөхөн төлөгдөөгүй.

Цагдаагийн байгууллагад 326 хохирогчийн 178 хэргийн асуудлаар хандаж, шүүхээр 61 хохирогчтой 24 хэргийг эцэслэн шийдвэрлүүлсэн байна.

## **ХХГХ-ийг таслан зогсоох чиглэлээр хийгдэж буй ажлууд**

Манай улсын хувьд сүүлийн 10 гаруй жилийн турш төрийн болон төрийн бус байгууллагууд идэвхитэй ажилласны үр дүнд олон эерэг үр дагаврууд гарч, үйл ажиллагааны хүрээ өргөжсөн. 2000 оны эхээр хүний наймааны талаар хийвсэр төсөөлөлтэй байсан иргэд 10 гаруй жилийн дараа гэхэд мэдлэгийн хүрээ нэмэгдэж, эрсдэлийн талаар тодорхой мэдээлэлтэй болж чадсан нь үүний нэг илрэл гэж үзэж болно.

Хууль, эрх зүйн орчны хувьд ч Эрүүгийн хуулиндаа тусгайлсан заалт (2002.09.01, 113-р зүйл) оруулснаас эхлээд нийтдээ 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулж ОУ-ын стандартад нийцүүлсэн. НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орж (2008.05), Хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хуулийг батлан гаргасан (2012.01.19) зэрэг олон алхмууд хийгдсэн.

Хохирогчдод туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд ч амжилт гарч, цөөнгүй хөтөлбөр, бтандартууд батлагдлаа. Гэвч хуулийн хэрэгжилт, хохирогч хамгааллын асуудал, хөтөлбөрийн санхүүжилт хангалтгүй хэвээр байна.

## **ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

### **2015-2017 он:**

- Шинээр батлагдсан хууль, стандартуудын хэрэгжилт, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- 2015-2016 онд “Хохирогчийг хамгаалах байранд тавигдах нийтлэг шаардлага (MNS 6040:2009), “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага (MNS 6418:2013)-ыг биелүүлэх үүднээс холбогдох яам, агентлагуудтай хамтран ажиллах
- 2015-2018 Үйлчилгээний чиглэлээр ажилладаг төр, ТББ-уудад үйлчилгээний стандартын сургалтыг явуулж, үйл ажиллагааг нэг стандартад оруулах
- Хохирогч хамгааллын бодлогыг боловсруулахад оролцож батлуулах
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх
- Шинэчилсэн УЗ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Хүний наймаатай тэмцэх бие даасан өдөр, сурталчилгааны сартай болох
- Хөдөлмөр мөлжлөгийн асуудлыг хууль тогтоомж, төрийн бодлогын түвшинд тодорхойлох, гадаадаас авч буй ажиллах хүчинд зориулсан сургалтыг төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
- Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд нөхөн олговрын асуудлыг ОУ-ын туршлагад суурилан оруулах

### **2017-2019 он:**

- Академик сургалтуудад өөрчлөлт оруулах, бодит хэрэгжилт
- Хохирогч хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх
- ХХГХ-тэй тэмцэх механизмийг бий болгоход санаачлан оролцох
- Хохирогчдод туслалцаа үзүүлэх үйлчилгээг төрийн институтуудээр гүйцэтгэх бичиг баримтыг хамтран боловсруулах
- Сургалтын багц, модулуудыг нас, сэтгэхүйн онцлогт тохируулан боловсруулж, улсын хэмжээнд нэгдсэн журмаар нэвтрүүлэх

- Нөхөн олговор олгох асуудлаар хуулинд санал өгөх, батлуулах ажилд идэвхитэй санаачлан оролцох, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих,

**2019-2020 он:**

- ХХГХ-тэй тэмцэх институтийн тогтолцоог бий болгоход оролцох
- Төрөөс хохирогчдод үзүүлэх туслалцаа үйлчилгээг бүрэн санхжүүлдэг болгоход нөлөөлж ажиллах
- Их, дээд сургуулийн, ялангуяа хуулийн чиглэлийн сургуулиудын клиник сургалтын төвөөр дамжуулан практик сургалтын загварыг бий болгож нэвтрүүлэх

**Зорилт Нэг: Бүтэц:**



## **ХТЭТ-өөс дэвшүүлж буй үйл ажиллагааны үндсэн чиглэл**

### **1. Хохирогч хамгааллын чиглэлээр**

- Хохирогчдод туслалцаа үзүүлэх стандартыг хэрэгжүүлэх
- 2015-2016 онд “Хохирогчийг хамгаалах байранд тавигдах нийтлэг шаардлага (MNS 6040:2009), “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага (MNS 6418:2013)-ыг биелүүлэх үүднээс холбогдох яам, агентлагуудтай хамтран ажиллах
- 2015-2018 Үйлчилгээний чиглэлээр ажилладаг төр, ТББ-уудад үйлчилгээний стандартын сургалтыг явуулж, үйл ажиллагааг нэг стандартад оруулах
  - Хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлэх
  - Хохирогчдын дэмжих бүлэг ажиллуулах, төрөлжүүлэх /нээлттэй, хаалттай/
  - Эрүүл мэндийн болон сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах
  - Хохирогчдын бүртгэлийг боловсронгуй болгох тусгайлсан бүртгэлийн системтэй болох, үйл ажиллагааг тогтмолжуулах
  - Байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах
  - Эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх хөтөлбөрийн стандартыг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх

#### Гол хамтрах байгууллага:

- ХЗЯ
- ХАХНХЯ
- ХЯ
- ГХЯ
- Хүн худалдаалахтэй тэмцэх Дэд зөвлөл
- Боловсролын яам
- Эрүүл мэндийн яам
- Тахарын ерөнхий газар
- Мэргэшсэн ТББ-ууд
- ОУБ-ууд

### **2. Урьдчилан сэргийлэх чиглэлээр**

- a. Үндэсний хэмжээний сургагч багш нарыг бий болгох
- b. Их дээд сургуулийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах, мэргэжлийн бүлгүүдэд зориулсан гарын авлага боловсруулах
- c. Урьдчилан сэргийлэх сурталчилгааг өргөжүүлж орон нутаг дахь хуулийн байгууллагын ажилтнууд, ТББ-уудыг татан оролцуулах
- d. Орон нутгуудад мэдээлэл түгээгчдийг бэлтгэх
- e. Мэргэшсэн ажилтнуудын багийг бий болгох
- f. Сар бүрийн мэдээллийн хуудас гаргаж олон нийтийн сүлжээгээр түгээх
- g. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах, мэргэшсэн сэтгүүлчдийг бэлтгэх
- h. Итгэлийн утасны үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, мэдээллийн баазыг сайжруулах

Гол хамтрах байгууллага:

- ЦБ, шүүх, прокурор, тахарын алба, ИШХБ, УБЕГ
- Нийгмийн ухаан, хууль зүйн ухааны их, дээд сургуулиуд
- Эрдэмтэд, судлаачид, багш нарын клубууд
- Эрэн сурвалжлах сэтгүүлчийн клуб
- ТББ-ууд
- Сайн дурынхан, оюутан сурагчид

**3. Жендерийн тэгш эрхийн чиглэлээр**

- Жендерийн ялгаварлалаас бий болж буй хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглүүлэх
- Гарын авлага, материалыг боловсруулах
- Жендерийн тэгш эрхийн талаар бүх түвшнийхэнд зориулсан сургалт, сурталчилгааны материал, судалгааны тоо мэдээтэй болох

Гол хамтрах байгууллага:

- ХАХНХЯ
- Жендэрийн үндэсний хороо
- ОУБ
- ТББ-ууд
- Их, дээд сургуулиуд

**4. Хууль тогтоомжийн өөрчлөлт, нөлөөллийн үйл ажиллагаа**

- Улаанбаатар хот болон орон нутгуудад хуульчдын багийг бий болгох, хамтын ажиллагааг сайжруулах, харилцан туршлага солилцох үйл ажиллагаа явуулах
- Хуулийн байгууллагад хандаад амжилтгүй болж буй хэргүүд дээр case study хийх
- Бусад орны хуулиудын орчуулгыг хийх, ашиглах, хэвлүүлэн түгээх
- БНСУ, Япон, БНХАУ зэрэг улсуудтай 2 улс хоорондын хамтын ажиллагааны /ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр/ гэрээ байгуулахад нөлөөлөх
- Шинээр боловсруулагдаж буй хуулийн төслүүдэд санал өгөх, шаардлагатай мэдээллээр хангах

Гол хамтрах байгууллага:

- ХЗЯ
- ХСИС
- ГХЯ
- УЕПГ
- 

**5. Орон нутгийн салбарын үйл ажиллагаа:**

- Замын-Үүдийн салбарыг өргөжүүлэх, үйл ажиллагааны хүрээг тэлэх
- Өмнөговь аймагт салбар байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулж жигдрүүлэх
- Орон нутгуудад ХТЭТ-ийг төлөөлөх сайн дурын ажилтнуудтай болох

d.

**6. Ажилтнуудын тогтвортой байдлыг хадгалах**

- a. Мэргэшүүлэх сургалтын үйл явцыг тогтмол хийх
- b. ОУ-ын хэмжээнд зохион байгуулагдаж буй сургалт, семинар, аялалд оролцуулах
- c. Бусад байгууллагатай мэргэжилтэн солилцох, харилцан туршлага солилцох
- d. Ажилтнуудын хэлний мэдлэгийг дээшлүүлэх

**7. Бусад үйл ажиллагаа**

- a. Тайландын эмэгтэйчүүдийн сантай ажилтан солилцох талаар хамтран ажиллах
- b. GAATW-с зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхитэй оролцох
- c. БНСУ-д шинэ салбар нээх ажлыг идэвхижүүлэн шийдүүлэх
- d. Гон Конгийн IOM-тай хамтран ажиллаж, нэг ажилтнаа ажиллуулах

**8. Гол хамтрах байгууллага:**

Яам, агентлагууд:

- ХЗЯ
- ГХЯ-ны Консулын хэлтэс, Гэрээ, хамтын ажиллагааны хэлтэс
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
- Хөдөлмөрийн яам
- Цагдаагийн ерөнхий газар, ЗБГХТГ
- Иргэний бүртгэлийн ерөнхий газар
- Тахарын ерөнхий газар
- Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар
- Орон нутгийн засаг захиргааны байгууллага
- Орон нутгийн хууль сахиулах бүх байгууллагууд

Олон улсын байгууллагууд:

- БНСУ-ын IOM
- БНСУ-ын KOSUN
- Тайландын Эмэгтэйчүүдийн сан
- GAATW

9. **Хөрөнгө босгох үйл ажиллагаа:** Бие даасан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

10. Удирдах зөвлөлийн хурлаар оруулж батлуулах

11. Жил бүр үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх

**SWOT үнэлгээ**

**Давуу тал:**

**Сул тал:**

<ul style="list-style-type: none"> <li>- 14 жилийн ажлын туршлагатай</li> <li>- Тогтвортой үйл ажиллагаатай</li> <li>- Мэргэшсэн ажилтнуудтай</li> <li>- Өөрийн эзэмшлийн 2 хамгаалах байртай</li> <li>- Итгэлийн утастай</li> <li>- Материаллаг нөөцтэй</li> <li>- Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах бааз суурьтай</li> <li>- Салбартаа хамтран ажиллах холбоо харилцаатай</li> <li>- Ажлын ноу хау тай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тогтвортой бус байдал</li> <li>- Үйл ажиллагаагаа хангалттай сурталчилж чаддаггүй</li> <li>- Оффисийн байргүй</li> <li>- Ажиллах хүч хүрэлцээгүй</li> <li>- Хэлний мэдлэг хангалтгүй</li> <li>- Гадаад харилцаа муу</li> <li>- Техник, тоног төхөөрөмжүүд хуучирч, муудаж байгаа</li> <li>-</li> </ul>
<p><b><u>Боломж:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн эзэмшлийн хамгаалах байртай</li> <li>- Мэргэшсэн, сэтгэлтэй ажилтнуудтай</li> <li>- Үйл ажиллагаа явуулах бааз суурьтай</li> <li>- Энэ чиглэлээр ажилладаг байгууллага, хүмүүс, салбартаа танигдсан</li> </ul>	<p><b><u>Эрсдэл:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд олширсон</li> <li>- Өрсөлдөөн бий болсон</li> <li>- Мэргэшсэн ажиллах хүчин</li> <li>- Төр үйлчилгээгээ өөрөө хариуцна гэсэн мэдээлэл түгээж байгаа</li> <li>-</li> </ul>

### **Хүйсийн тэгш эрхийн төв**